

**Хөгжлийн бэрхшээлтэй хүний мэдээлэл авах эрхийг хангах чиглэлээр:
Телевизүүдийн дохионы хэл, хадмал тайлбартай нэвтрүүлэг
нэвтрүүлсэн байдал (2025 оны эхний хагас жил)**

Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.2.4 дэх хэсэгт “Монгол Улсын нутаг дэвсгэрт үйл ажиллагаа эрхлэх телевиз нь өөрийн хөтөлбөрөөр нэвтрүүлэх мэдээ, мэдээллийн нэвтрүүлэг, танин мэдэхүй, хүүхдийн нэвтрүүлэг зэргийг дохионы хэлний хэлмэрчтэй эсхүл хадмал тайлбартай гаргах үе шаттайгаар төлөвлөгөөг боловсруулж, хэрэгжүүлнэ” гэж заасан байдаг.

Харилцаа холбооны зохицуулах хорооноос Өргөн нэвтрүүлгийн тухай хуулийн 30 дугаар зүйлийн 30.1.6-д заасан “Телевизийн хөтөлбөрт тавигдах шаардлага”-ын 3.17-д заасны дагуу Монгол Улсад хамрах хүрээтэй телевизүүдэд мэдээ, мэдээллийн хөтөлбөр, хүүхдийн болон танин мэдэхүйн нэвтрүүлгийг дохионы хэлмэрчтэй эсхүл хадмал тайлбартай гаргах үе шаттай төлөвлөгөөг өөрийн боломжид тулгуурлан редакцын бодлогын хүрээнд төлөвлөж төлөвлөгөөний дагуу гаргах үүргийг хүлээлгэсэн болно. Энэ нь дохионы хэлний хэлмэрчийн олдоц хязгаарлагдмал байдлыг харгалзан шат дараатай авч буй арга хэмжээний нэг юм.

Өнөөгийн байдлаар Монгол Улсад хамрах хүрээтэй Улаанбаатар хотын өргөн нэвтрүүлгийн 18, орон нутгийн 3 телевиз болон хөтөлбөртөө цаг үеийн мэдээ, мэдээлэл, хүүхдийн болон танин мэдэхүйн нэвтрүүлгүүд тусган нэвтрүүлдэг арилжааны 26, нийт 47 телевиз дохионы хэлтэй, эсхүл хадмал тайлбартай нэвтрүүлэг нэвтрүүлэх үүрэг хүлээж байна. Харин Монгол Улсад хамрах хүрээтэй боловч спорт, кино, теле-худалдаа зэрэг төрөлжсөн хөтөлбөртэй, хөтөлбөрт нь мэдээ, мэдээлэл, танин мэдэхүй, хүүхдийн нэвтрүүлэг байхгүй 13 арилжааны телевизийн хувьд дохионы хэл, хадмал тайлбартай нэвтрүүлэг нэвтрүүлэх үүрэг хүлээлгээгүй болно.

Энэхүү тайлангаар телевизүүд мэдээ мэдээлэл, танин мэдэхүй, хүүхдийн нэвтрүүлгийг дохионы хэл, хадмал тайлбартай хэрхэн нэвтрүүлсэн талаарх телевизүүдийн хөтөлбөрийн 2025 оны эхний хагас жилийн хяналт, мониторингийн дүн мэдээ мөн 2025 оны эхний хагас жилд телевизүүд тухайн онд нэвтрүүлэхээр төлөвлөсөн дохионы хэлний хэлмэрчтэй, хадмал тайлбартай нэвтрүүлгийнхээ хувь хэмжээнд хүрсэн эсэхийг нэгтгэн гаргаж байна.

2025 оны хагас жилийн байдлаар МҮОНРТ-ийн 1 телевиз, өргөн нэвтрүүлгийн 17 телевиз, орон нутгийн 1 телевиз, Монгол Улсад хамрах хүрээтэй 23 телевиз мөн үүрэг хүлээгээгүй боловч телевизийн редакцын хүрээнд 7 телевиз буюу нийт **40** телевизээр **3462** цагийн дохионы хэлтэй нэвтрүүлэг нэвтрүүлжээ. Нийт цагийн **72.74%-д 14** телевизээр **мэдээ, мэдээлэл, 11.33%-д 17** телевизээр **танин мэдэхүйн нэвтрүүлэг**, харин **3.91%-д нь 8** телевизээр **хүүхдийн** нэвтрүүлгийг тус тус дохионы хэлтэй нэвтрүүлсэн байна. Хадмал тайлбартай нэвтрүүлгийн хувьд нийт **40** телевиз **1611** цагийн нэвтрүүлэг нэвтрүүлсэн ба нийт цагийн **52.86%-д 22** телевизээр **танин мэдэхүйн** нэвтрүүлэг, **0.47%-д 1** телевизээр **мэдээ, мэдээллийн** нэвтрүүлэг, **9.22%-д 7** телевиз **хүүхдийн** нэвтрүүлгийг тус тус нэвтрүүлжээ.

Өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад дохионы хэлний хэлмэрчтэй нэвтрүүлэг нэвтрүүлсэн телевиз 13-аар, хадмал тайлбартай нэвтрүүлсэн телевиз 7-оор тус тус багассан байна. Энэ нь 2024 онд Монгол Улсын Их хурлын болон Аймаг нийслэл, сум, дүүргийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын ээлжит сонгууль болсонтой хамааралтай юм.

2025 онд 39 телевизээр нэвтрүүлсэн дохионы хэл бичгэн тайлбартай
нэвтрүүлгийн төрөл жанр /хувь/

**ДОХИОНЫ ХЭЛТЭЙ НЭВТРҮҮЛСЭН НЭВТРҮҮЛГИЙН
ТӨРӨЛ ЖАНР, ХУВЬ ХЭМЖЭЭ**



**БИЧГЭН ТАЙЛБАРТАЙ НЭВТРҮҮЛСЭН
НЭВТРҮҮЛГИЙН ТӨРӨЛ ЖАНР, ХУВЬ ХЭМЖЭЭ**



Тайлбар: Дохионы хэлтэй нэвтрүүлсэн нэвтрүүлгийн хувь хэмжээг харахад мэдээ мэдээллийг дохионы хэлтэй нэвтрүүлсэн байдал 72.74%, танин мэдэхүйн нэвтрүүлгийг 11.33%, хүүхдийн нэвтрүүлэг 3.91%-тай нэвтрүүлсэн байгаа нь өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад танин мэдэхүйн нэвтрүүлэг 5%, хүүхдийн нэвтрүүлэг 2%-иар өссөн үзүүлэлттэй байна. Мөн бичгэн тайлбартай нэвтрүүлсэн нэвтрүүлгийн хувьд 52.86%, танин мэдэхүйн нэвтрүүлэг, хүүхдийн нэвтрүүлэг 9%-тай байгаа өнгөрсөн оны мөн үеэс танин мэдэхүйн нэвтрүүлэг 5%, хүүхдийн нэвтрүүлэг 3% өссөн үзүүлэлт юм.

Дээрх хувь хэмжээнээс харахад Монгол Улсад хамрах хүрээтэй телевизүүд нь цаг үеийн мэдээ мэдээлэл, танин мэдэхүйн нэвтрүүлэг, хүүхдийн нэвтрүүлгийг дохионы хэлний хэлмэрчтэй, хадмал тайлбартай нэвтрүүлэх талаар бодит төлөвлөлт хийж хувь хэмжээг шат дараатай нэмж байна.

Дохионы хэл, хадмал тайлбартай нэвтрүүлсэн нийт нэвтрүүлгийн байдал

2025 оны эхний хагас жилийн байдлаар

	Нэвтрүүлгийн төрөл	Телевизийн тоо	Нийт (цаг:мин:сек)	Нийт нэвтрүүлэгт эзлэх хувь
Дохионы хэлний хэлмэрчтэй нэвтрүүлсэн нэвтрүүлэг	Мэдээ мэдээллийн нэвтрүүлэг	14	2518:21:53	72.74%
	Хүүхдийн нэвтрүүлэг	8	135:23:17	3.91%
	Танин мэдэхүйн нэвтрүүлэг	17	392:17:47	8.35%
	Бусад нэвтрүүлэг (кино, нийгэм, улс төр, соёл урлаг, спорт, цэнгээнт,шашин)	Кино-3 Нийгэм улс төр-25 Соёл урлаг-1 Спорт-1 Цэнгээнт-17 Шашин-2	Кино-59:46:03 Нийгэм улс төр-399:17:30 Соёл урлаг-02:51:20 Спорт- 04:49:20 Цэнгээнт-03:22:14 Шашин-00:52:32	Кино-0.13% Нийгэм улс төр-11.53% Соёл урлаг-0.08% Спорт-0.14% Цэнгээнт-0.10% Шашин-0.03%
	НИЙТ	40 ТВ	3461:57:29	
Хадмал тайлбартай нэвтрүүлсэн нэвтрүүлэг	Мэдээ мэдээллийн нэвтрүүлэг	1	07:29:48	0.47%
	Хүүхдийн нэвтрүүлэг	7	148:34:17	9.22%
	Танин мэдэхүйн нэвтрүүлэг	22	851:36:57	52.86%
	Бусад нэвтрүүлэг (нийгэм, улс төр, соёл урлаг, цэнгээнт,шашин)	Нийгэм улс төр-29 Соёл урлаг-4 Цэнгээнт-6 Шашин-1	Нийгэм улс төр-553:22:55 Соёл урлаг-23:58:08 Цэнгээнт-11:11:05 Шашин-14:44:02	Нийгэм улс төр-34.35% Соёл урлаг-1.49% Цэнгээнт-0.69% Шашин-0.91%
	НИЙТ	40 ТВ	1611:03:42	

1. Дохионы хэлний хэлмэрчтэй нэвтрүүлсэн нэвтрүүлгийн тайлан /телевиз тус бүрээр/


1.1 Мэдээ, мэдээллийн нэвтрүүлгийг дохионы хэлтэй нэвтрүүлсэн телевизүүд

2025 оны эхний хагас жилийн байдлаар

№	Телевизийн нэр	Дохионы хэлтэй нэвтрүүлсэн мэдээ, мэдээллийн хөтөлбөрийн цаг
Үндэсний олон нийтийн телевиз		
1.	MNB	232:07:53
2.	MNB Монголын мэдээ	172:36:26
Өргөн нэвтрүүлгийн телевиз		

3.	C1	164:44:27
4.	NTV	261:12:24
5.	SBN	227:36:53
6.	UBS	281:48:24
7.	Ийгл ньюс	409:59:03
8.	Монгол HD	73:01:34
9.	TB5	50:45:43
10.	TB8	230:30:54
11.	TB9	143:01:13
12.	Тэнгэр ТВ	259:54:52
Арилжааны телевиз		
13.	ОНТВ	1:02:07
	Нийт цаг	2518:21:53
	Нийт дохионы хэлд харьцуулсан	72.74%

Дээрх нэр бүхий 13 телевиз өдөр тутмын мэдээллийн хөтөлбөрөө тодорхой хэмжээнд дохионы хэлтэй нэвтрүүлжээ. Өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад өргөн нэвтрүүлгийн телевиз 1-р нэмэгдсэн бол арилжааны телевизээс 12 телевиз хасагдсан үзүүлэлттэй байна.



1.2 Танин мэдэхүйн нэвтрүүлгийг дохионы хэлтэй нэвтрүүлсэн телевизүүд


2025 оны эхний хагас жилийн байдлаар

№	Телевизийн нэр	Дохионы хэлтэй нэвтрүүлсэн танин мэдэхүйн нэвтрүүлгийн цаг
Өргөн нэвтрүүлгийн телевиз		
1.	SBN	0:15:35
2.	UBS	2:04:58
3.	ETB	0:15:43
4.	Ийгл ньюс	1:34:00
5.	Малчин	3:43:22
6.	Стар	0:18:22
7.	TB5	43:12:09
8.	TB8	0:15:42
Арилжааны телевиз		
9.	Movie Max	47:35:14

10.	National times news	40:43:39
11.	News Channel	10:26:53
12.	Гандан ТВ	11:28:01
13.	Их Засаг	75:56:29
14.	Лайк ТВ	50:06:54
15.	ОНТВ	71:54:45
16.	Соён гэгээрүүлэгч	00:35:08
17.	Хөгжил ТВ	31:50:53
	Нийт цаг	392:17:47
	Нийт дохионы хэлд харьцуулсан	11.33%

Дээрх телевизүүдээс Лайк, Хөгжил, Өлзий, News channel, National times news телевизүүд нь эрүүл мэндийн зөвлөгөө, зөвлөмжийн нэвтрүүлгээ тогтмол дохионы хэлтэй нэвтрүүлдэг. Харин Стар, TV5, Moviemax, Гандан телевизүүд нь Түүх, соёл, зан заншлын нэвтрүүлгийг, бусад телевизүүд боловсролын нэвтрүүлгийг дохионы хэлтэй нэвтрүүлж байна.

Танин мэдэхүйн нэвтрүүлгийг дохионы хэлтэй нэвтрүүлсэн эфирийн нийт хугацаа болон өөрийн бүтээж нэвтрүүлсэн дохионы хэлний цагийг 2021-2025 оноор доор харьцуулан харахад буурсан үзүүлэлтэй байна.



1.3 Хүүхдийн нэвтрүүлгийг дохионы хэлтэй нэвтрүүлсэн телевизүүд


2025 оны эхний хагас жилийн байдлаар

№	Телевизийн нэр	Дохионы хэлтэй нэвтрүүлсэн хүүхдийн нэвтрүүлгийн цаг
Өргөн нэвтрүүлгийн телевиз		
1.	Централ	14:10:03
2.	NTV	4:28:51
3.	Боловсрол суваг	8:20:17
4.	ETV	5:13:31
5.	TB5	49:43:09
Арилжааны телевиз		
6.	Dream	7:29:07
7.	Movie Max	43:51:41
8.	Масс ТВ	02:06:38
	Нийт цаг	135:23:17
	Нийт дохионы хэлд харьцуулсан	3.91%


2024 онд телевизүүд нийт **135** цагийн хүүхдийн нэвтрүүлгийг дохионы хэлтэй нэвтрүүлсэн байна. Эдгээрээс Централ, Боловсрол суваг, NTV телевизүүд нь хүүхдийн нэвтрүүлэгтэй болж дохионы хэлмэрчтэйгээр нэвтрүүлж эхэлжээ.


“Телевизээр хөтөлбөрт тавигдах шаардлага”-ын 3.10.5-д 6+, 12+ буюу бага, өсвөр насны хүүхдийн нэвтрүүлгийн нийт цагийн 20 хувиас доошгүй нь дохионы хэлний хэлмэрчтэй эсхүл хадмал тайлбартай байна гэж заасан байдаг. 2025 оны эхний хагас жилд SBN 34%-тай, Movie max 44%-тай, Дрийн тв нь 91%-тай нэвтрүүлж дээрх нөхцөл шаардлагыг ханган ажилласан байна.

Хүүхдийн нэвтрүүлгийг дохионы хэлтэй нэвтрүүлсэн эфирийн нийт хугацаа болон өөрийн бүтээж нэвтрүүлсэн дохионы хэлний цагийг 2021-2025 оноор харьцуулан гаргахад дохионы хэлтэй нэвтрүүлсэн цаг өнгөрсөн оны мөн үеэс өссөн үзүүлэлттэй байна.



1.4 Бусад нэвтрүүлгийг дохионы хэлний хэлмэрчтэй нэвтрүүлсэн байдал





2. Телевизүүдээр нэвтрүүлсэн хадмал тайлбартай нэвтрүүлгийн тайлан


2.1 Мэдээ, мэдээллийн нэвтрүүлгийг хадмал тайлбартай нэвтрүүлсэн телевизүүд

2025 оны эхний хагас жилийн байдлаар

№	Телевизийн нэр	Дохионы хэлтэй нэвтрүүлсэн мэдээ, мэдээллийн хөтөлбөрийн цаг
Өргөн нэвтрүүлгийн телевиз		
1.	Малчин	7:29:48
	Нийт цаг	7:29:48
	Нийт бичгэн тайлбартай харьцуулсан	0.47%

Мэдээ, мэдээллийн хөтөлбөрийн хувьд ихэнх телевизүүд дохионы хэлний хэлмэрчтэй гаргаж байгаа бол хадмал тайлбартай мэдээ, мэдээллийн нэвтрүүлэг нэвтрүүлж байгаа телевизийн тоо, хугацаа бага байна.

Мэдээ, мэдээллийн нэвтрүүлэг бичгэн тайлбартай нэвтрүүлсэн эфирийн нийт хугацаа болон өөрийн бүтээж нэвтрүүлсэн дохионы хэлний цагийг 2023-2025 оноор харьцуулан гаргасан доорх графикаас харахад 2023 оноос эхлэн хадмал тайлбартай гаргасан мэдээ, мэдээллийн нэвтрүүлгийн цаг багасаж дохионы хэлтэй нэвтрүүлсэн мэдээ, мэдээллийн нэвтрүүлгийн цаг буурсан харагдаж байна.




2.2 Танин мэдэхүйн нэвтрүүлгийг хадмал тайлбартай нэвтрүүлсэн телевизүүд

2025 оны эхний хагас жилийн байдлаар

№	Телевизийн нэр	Дохионы хэлтэй нэвтрүүлсэн танин мэдэхүйн нэвтрүүлгийн цаг
Өргөн нэвтрүүлгийн телевиз		
1.	Централ	205:25:11
2.	SBN	14:58:47
3.	Боловсрол	33:09:15
4.	Ийгл ньюс	53:51:31
5.	Малчин	5:05:07
6.	TB5	88:43:35
7.	Стар	80:25:28
8.	Тэнгэр ТВ	16:00:33
9.	Монгол HD	15:15:34
10.	UBS	0:04:08
11.	TB9	34:22:25
Арилжааны телевиз		
12.	Мянгат Малчин ТВ	06:14:18
13.	ОНТВ	71:54:45
14.	Movie Max	65:58:44
15.	Монгол TB1+	16:12:33
16.	Dream TV	2:48:11
17.	National times news	84:00:06
18.	Авто ТВ	0:11:50
19.	TB3	2:21:03
20.	Гандан ТВ	0:16:10
21.	Хөх Монгол	0:03:16
22.	MonPlus	1:15:55
23.	Парламент	0:03:58
24.	Талын Монгол	2:21:03
25.	Эко	53:02:08
	Нийт цаг	851:36:57
	Нийт бичгэн тайлбартай харьцуулсан	52.86%

Танин мэдэхүйн нэвтрүүлгийн хувьд телевизүүд дохионы хэлтэй гаргахаас илүүтэйгээр хадмал тайлбартай гаргаж байгаа нь дээрх хувь хэмжээнээс харагдаж байна. Дохионы хэлтэй нэвтрүүлсэн танин мэдэхүйн нэвтрүүлгийн хувь 11.33 байсан бол хадмал тайлбартай нэвтрүүлсэн нэвтрүүлгийн хувь 50.60 байна. Түүнчлэн танин мэдэхүйн нэвтрүүлгийг хадмал тайлбартай нэвтрүүлж байсан телевизийн тоо өмнөх оны мөн үеэс 13-аар нэмэгджээ.

Мөн доорх бичгэн тайлбартай нэвтрүүлсэн эфирийн нийт хугацаа болон өөрийн бүтээж нэвтрүүлсэн дохионы хэлний цагийг 2021-2025 оноор харьцуулан гаргахад хадмал тайлбартай нэвтрүүлсэн цаг өнгөрсөн оны мөн үеэс буурсан үзүүлэлттэй байна.




2.3 Хүүхдийн нэвтрүүлгийг хадмал тайлбартай нэвтрүүлсэн телевизүүд

2025 оны хагас жилийн байдлаар


№	Телевизийн нэр	Дохионы хэлтэй нэвтрүүлсэн хүүхдийн нэвтрүүлгийн цаг
Өргөн нэвтрүүлгийн телевиз		
1.	C1	06:00:00
2.	SBN	13:25:48
3.	UBS	1:17:27
4.	Монгол HD	25:24:39
Арилжааны телевиз		
5.	National times news	39:04:17
6.	Dream TV	63:21:24
	Нийт цаг	148:35:17
	Нийт бичгэн тайлбартай харьцуулсан	9.22%

Хүүхдийн нэвтрүүлгийн хувьд телевизүүд дохионы хэлтэй гаргахаас илүүтэйгээр хадмал тайлбартай нэвтрүүлгүүд гаргаж байгаа нь дээрх хувь хэмжээнээс харагдаж байна. Хадмал тайлбартай хүүхдийн нэвтрүүлгийн дийлэнх хувийг Балчир насны нэвтрүүлэг эзэлж байна.

Мөн доорх хадмал тайлбартай нэвтрүүлсэн эфирийн нийт хугацаа болон өөрийн бүтээж нэвтрүүлсэн дохионы хэлний цагийг 2023-2025 оноор харьцуулан гаргахад хадмал тайлбартай нэвтрүүлсэн цаг өнгөрсөн оноос буурчээ.



2.4 Бусад нэвтрүүлгийг хадмал тайлбартай нэвтрүүлсэн байдал



Дээрх хадмал тайлбартай нэвтрүүлсэн эфирийн нийт хугацаа болон өөрийн бүтээж нэвтрүүлсэн бичгэн тайлбартай цагийг 2023-2025 оноор харьцуулан харахад хадмал тайлбартай нэвтрүүлсэн нэвтрүүлгийн цаг буурсан үзүүлэлттэй байна.

2025 оны эхний улиралд тус хороо нь Монгол Улсад хамрах хүрээтэй Улаанбаатар хотын өргөн нэвтрүүлгийн 18, орон нутгийн 3 телевиз болон хөтөлбөртөө цаг үеийн мэдээ, мэдээлэл, хүүхдийн болон танин мэдэхүйн нэвтрүүлгүүд тусган нэвтрүүлдэг арилжааны 26, нийт 47 телевизээс дохионы хэлтэй, эсхүл хадмал тайлбартай нэвтрүүлэх нэвтрүүлгийн төлөвлөлтийг 2025 оны хагас жилээр ирүүлэхийг мэдэгдсэн. Үүний дагуу арилжааны нэр бүхий 4 телевизээс бусад 43 телевизийн төлөвлөгөөгөө ирүүлснийг хорооны цахим хуудсаар мэдээлсэн. Эдгээр 43 телевиз төлөвлөлтийн дагуу дохионы хэлний хэлмэрчтэй, хадмал тайлбартай нэвтрүүлгээ хэрхэн нэвтрүүлсэн тухай тайланг 2025 оны хагас жилээр гаргалаа.

📺 **Өргөн нэвтрүүлгийн телевиз**

№	ТВ нэр	Нэвтрүүлгийн төрөл	Нийт хугацаа (секундээр)		Хөтөлбөрт эзлэх хувь-2025 эхний хагас жил				Нийт хувь	2025 оны хагас жилийн гүйцэтгэл
			Хадмал тайлбар	Дохионы хэл	Нийт	Хадмал тайлбар	Дохионы хэл	Аль аль нь байгаа		Хувь
1	Ийгл ньюс	мэдээ, мэдээллийн нэвтрүүлэг		3,276,000	6,683,040		29.4%		60.0%	15%
		Танин мэдэхүйн нэвтрүүлэг	1,135,680			10.2%				
		Танин мэдэхүйн нэвтрүүлэг	1,135,680			10.2%				
		Танин мэдэхүйн нэвтрүүлэг	1,135,680			10.2%				

2	Монгол HD	мэдээ, мэдээллийн нэвтрүүлэг		448,800	1,126,200		4.0%		10.1%	5%
		мэдээ, мэдээллийн нэвтрүүлэг		249,600			2.2%			
		Ярилцлагын нэвтрүүлэг	217,800			2.0%				
		Танин мэдэхүйн нэвтрүүлэг	210,000			1.9%				
3	ETV	Хүүхдийн нэвтрүүлэг		72,000	331,200		0.6%		1.0%	0
		Хүүхдийн нэвтрүүлэг		43200			0.00			
		Санамж, уриалга	1,800	216,000		0.0%				
4	NTV	Цагийн үеийн мэдээ, мэдээллийн нэвтрүүлэг		1,404,000	1,431,000		9.74%		9.93%	6.9%
		Хүүхдийн нэвтрүүлэг	27,000			0%				
5	Стар	Танин мэдэхүйн нэвтрүүлэг	27,000		81,000	0.26%			0.77%	2.8%
		Танин мэдэхүйн нэвтрүүлэг	27,000			0.26%				
		Хүүхдэд зориулсан нэвтрүүлэг	27,000			0.26%				
6	TM	Цаг үеийн мэдээ		117,000	351,000		1.05%		3.15%	0.0%
		Үндэсний түүх		70,200			0.63%			
		Танин мэдэхүйн нэвтрүүлэг		93,600			0.84%			
		Танин мэдэхүйн нэвтрүүлэг		70,200			0.63%			
7	ТВ9	Мэдээллийн хөтөлбөр		1,555,200			10.79%		10.79%	3.6%
8	Малчин	Цаг агаарын хөтөлбөр		59,400	118,800		0.53%		1.07%	0.12%
		Цаг агаарын хөтөлбөр		59,400			0.53%			
9	Централ	Танин мэдэхүйн нэвтрүүлэг	1,656,000		4,234,500	14.0%			35.9%	6.7%
		Танин мэдэхүйн нэвтрүүлэг	252,000			2.1%				
		Танин мэдэхүйн нэвтрүүлэг	2,070,000			17.6%				
		Танин мэдэхүйн нэвтрүүлэг	13,500			0.1%				
		Танин мэдэхүйн нэвтрүүлэг	27,000			0.2%				
		Ярилцлагын нэвтрүүлэг	216,000			1.8%				

10	C1	Өдөр тутмын мэдээллийн хөтөлбөр		534,000	603,120		4.53%		5.11%	5.6%
		Ярилцлагын нэвтрүүлэг		69,120			0.59%			
11	TB5	Цаг үеийн мэдээ		115,200	648,000		0.98%		5.49%	7.1%
		Танин мэдэхүйн нэвтрүүлэг	288000				2.44%			
		Танин мэдэхүйн нэвтрүүлэг	28800				0.24%			
		Хүүхдийн нэвтрүүлэг		216,000			1.83%			
12	TB8	Цаг үеийн мэдээ		2,808,000	2,917,200		23.81%		24.74%	8.6%
		Хүүхдэд зориулсан нэвтрүүлэг		109,200			0.93%			
13	Боловсрол суваг	Танин мэдэхүйн нэвтрүүлэг	270000		931,200	2.6%			8.7%	1.1%
			14400			0%				
			85800			0.8%				
			33000			0.3%				
			33000			0.3%				
			495000			4.7%				
14	UBS	Цаг үеийн мэдээ	65520			0.6%			0.6%	9.2%
		танин мэдэхүй								
		Хүүхдийн нэвтрүүлэг								
15	25-р суваг	Хүүхдийн нэвтрүүлэг	90000		270,000	0.9%			2.6%	0%
		Иргэдийн үзэл бодол	67500			0.6%				
		Залуучуудад зориулсан хөрөг нэвтрүүлэг	112500			1.1%				
16	Сүлд	Цаг үеийн мэдээ		702,000	1,134,000	6.0%			9.6%	0%
		Хүүхдийн нэвтрүүлэг		432,000				4%		
17	Тэнгэр	Цаг үеийн мэдээ		936,000	1,169,100		7.94%		9.91%	8.4%
		Танин мэдэхүйн нэвтрүүлэг	93600			0.8%				
		Танин мэдэхүйн нэвтрүүлэг	139500			1.2%				
18	SBN	Цаг үеийн мэдээ		896,400	1,358,640		7.60%		11.52%	7.8%
		Хүүхдийн нэвтрүүлэг	345600			0.03				
		Ярилцлагын нэвтрүүлэг	58320			0.00				
		Ярилцлагын нэвтрүүлэг	58320			0.00				

№	ТВ нэр	Нэвтрүүлгийн төрөл	Нийт хугацаа (секундээр)		Хөтөлбөрт эзлэх хувь-2025 эхний хагас жил				Нийт хувь	2025 оны хагас жилийн гүйцэтгэл
			Хадмал тайлбар	Дохионы хэл	Нийт	Хадмал тайлбар	Дохион ы хэл	Аль аль нь байгаа		Хувь
1	Dreambox	Үндэсний түүх уламжлал	-	63,000	931,200	-	0.6%	-	8.9%	2.53%
		Үндэсний түүх уламжлал	105,000	-		1.0%	-	-		
		ТВ хичээл	259,200	-		2.5%	-	-		
		Танин мэдэхүйн нэвтрүүлэг	172,800	-		1.6%	-	-		
		Танин мэдэхүйн нэвтрүүлэг	79,200	-		0.8%	-	-		
		Ток шоу	162,000	-		1.5%	-	-		
		Танин мэдэхүйн нэвтрүүлэг	90,000	-		0.9%	-	-		
2	Блумберг ТВ Монголиа	Ярилцлагын нэвтрүүлэг	115,200	-	224,640	1.1%	-	-	2.1%	0.51%
		Ярилцлагын нэвтрүүлэг	86,400	-		0.8%	-	-		
		Ярилцлагын нэвтрүүлэг	23,040	-		0.2%	-	-		
3	Moviemax	Танин мэдэхүй	201,600	-	971,501	1.7%	-	-	8.2%	4.81%
		Хүүхдэд зориулсан нэвтрүүлэг	-	157,901		-	1.3%	-		
		Өв соёл	-	612,000		5%	-	-		
4	Мянгат малчин	Танин мэдэхүй	423,360	-	423,360	2.69%	-	-	2.69%	0.22%
5	Масс Тв	Мэдээллийн хөтөлбөр	-	26,400	136,800	-	0.22%	-	1.16%	1.05%
		Танин мэдэхүйн нэвтрүүлэг	-	74,400		-	0.63%	-		
		Хүүхдэд зориулсан нэвтрүүлэг	-	36,000		-	0.31%	-		
6	Бидний цөөхөн Монголчууд	Танин мэдэхүйн нэвтрүүлэг	82,500		161,700	-	0.79%	-	1.54%	0.00%
		Танин мэдэхүйн нэвтрүүлэг	79,200			-	0.76%	-		
7	Хөгжил ТВ	Танин мэдэхүйн нэвтрүүлэг		32,400	32,400	-	0.25%	-	0.25%	0.89%
8	Гандан	Танин мэдэхүйн нэвтрүүлэг	19,200	-	36,000	0.18%	-	-	0.34%	1.02%
			16,800	-		0.16%	-	-		
9	Чаннел 11	Хүүхдэд зориулсан нэвтрүүлэг	-	109,200	109,200	0.9%	-	-	0.9%	0.00%

10	Талын Монгол	Монгол үндэсний өв соёл уламжлалын нэвтрүүлэг	-	259,200	259,200	-	2.20%	-	2.20%	0.18%
11	Монгол ТВ+1	Танин мэдэхүйн нэвтрүүлэг	86,400	-	86,400	1.32%	-	-	1.32%	1.24%
12	ТВ3	Танин мэдэхүйн нэвтрүүлэг	108000	-	280,800	1.0%	-	-	2.68%	0.08%
			64800	-		0.6%	-	-		
			108000	-		1.0%	-	-		
13	NTN	Боловсрол	-	118800	762960	-	1.07%	-	6.85%	5.29%
		Танин мэдэхүйн нэвтрүүлэг	118800	-		1.07%	-	-		
		Асуудал дэвшүүлсэн нэвтрүүлэг	34320	-		0.31%	-	-		
		Баримтад тулгуурласан нэвтрүүлэг	158400	-		1.42%	-	-		
		Ярилцлагын нэвтрүүлэг	332640	-		2.99%	-	-		
14	Их засаг	Танин мэдэхүйн нэвтрүүлэг	-	144000	144000	-	1.37%	-	1.37%	2.99%
15	Өлзий	Танин мэдэхүйн нэвтрүүлэг	342000	-	342000	2.37%	-	-	2.37%	0.28%
16	Лайк	Ярилцлагын нэвтрүүлэг	-	43200	86400	-	0.39%	-	0.78%	1.62%
		Ярилцлагын нэвтрүүлэг	-	43200		-	0.39%	-		
17	Лайв	Цаг үеийн мэдээ	1920	-	1920	0.02%	-	-	0.02%	0.43%
18	Эко	Танин мэдэхүйн нэвтрүүлэг	543000	-	543000	5%	-	-	5%	1.82%
19	ОНТВ	Танин мэдэхүйн нэвтрүүлэг	331200		1267200	-	-	3.16%	12.09%	4.97%
		Цаг үеийн мэдээ	-	936000		-	8.93%	-		
20	Аист Глобал	Мэдээллийн хөтөлбөр	79200	-	-	0.71%	-	-	7%	0.00%
		Хүүхдэд зориулсан нэвтрүүлэг	420000	-	-	3.77%	-	-		
		Түүхэн нэвтрүүлэг	237600	-	-	2.13%	-	-		
		Соёл урлаг	22200	-	-	0.20%	-	-		
		Түүхэн нэвтрүүлэг	31200	-	-	0.28%	-	-		
		Түүхэн нэвтрүүлэг	3600	-	-	0.03%	-	-		
		Түүхэн нэвтрүүлэг	22200	-	-	0.20%	-	-		
21	Соён гэгээрүүлэгч	Танин мэдэхүйн нэвтрүүлэг	921600	-	-	5.86%	-	-	5.86%	0.01%
22	ТВ 2	Цаг үеийн мэдээ	54300	-	-	0.49%	-	-	0.49%	0.00%

 Монгол Улсад хамрах хүрээтэй орон нутгийн телевиз

№	ТВ нэр	Нэвтрүүлгийн төрөл	Нийт хугацаа (секундээр)		Хөтөлбөрт эзлэх хувь-2025 эхний хагас жил				Нийт хувь	2025 оны хагас жилийн гүйцэтгэл
			Хадмал тайлбар	Дохионы хэл	Нийт	Хадмал тайлбар	Дохионы хэл	Аль аль нь байгаа		Хувь
1	ТВ24	мэдээ, мэдээллийн нэвтрүүлэг	-	1,310,400	1,716,000	-	12.5%	-	16.4%	5.2%
		Хүүхдэд зориулсан нэвтрүүлэг	-	187,200		-	1.8%	-		
		Үндэсний түүх өв соёлын нэвтрүүлэг	156,000	-		-	-	1.5%		
		Танин мэдэхүйн нэвтрүүлэг	62,400	-		-	-	0.6%		
2	X television	Мэдээ, мэдээллийн нэвтрүүлэг	90,000	-	1,909,200	-	0.9%	-	18.2%	0%
		Ярилцлага	144,000	-		-	1.4%	-		
		Танин мэдэхүйн нэвтрүүлэг	162,000	-		-	1.5%	-		
		Үндэсний түүх уламжлалын нэвтрүүлэг	54,000	-		-	-	0.5%		
		Үндэсний түүх уламжлалын нэвтрүүлэг	72,000	-		-	-	0.7%		
		Хүүхдэд зориулсан нэвтрүүлэг	244,800	-		-	-	2.3%		
		Хүүхдэд зориулсан нэвтрүүлэг	1,142,400	-		-	-	10.9%		
3	BBS ТВ	Мэдээ, мэдээллийн нэвтрүүлэг	816,000	-	816,000	7.8%	-	-	7.8%	0%

ХАРИЛЦАА ХОЛБООНЫ ЗОХИЦУУЛАХ ХОРОО

--oOo--